

**ООСОРЛОГЧ, ДОХИОЧНЫ ЭРХ ОЛГОХ СУРГАЛТЫН
АЖЛЫН ДААЛГАВАР**

№	АГУУЛГА	
1	Зорилго	Салбарын үйл ажиллагаанд өргөх, зөөх төхөөрөмж, түүний аюулгүй ажиллагаа, оосорлох хэрэгслийн талаар ажил, үүргээ гүйцэтгэхэд ажилтныг мэргэшүүлж, эрх сунгана.
2	Зорилт	Сургалтын хэрэгцээнд үндэслэн чанартай, үр дүнтэй сургалтыг зохион байгуулах.
3	Хэрэгцээ, шаардлага	Компанийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтыг Олон Улсын шаардлагын дагуу гүйцэтгэж, ажлын бүтээмжийг тасралтгүй сайжруулж ажиллах.
4	Сэдэв	Сургалтыг дараах сэдвүүд болон шаардлагатай бусад сэдвүүдийг нэмж явуулах. • Кран, өргөх төхөөрөмжийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал • Кран, өргөх төхөөрөмжийн ерөнхий бүтэц, ажиллах зарчим, ангилал • Кран, өргөх төхөөрөмжийн эд ангиудын бүтэц, онцлог • Орчин үеийн кран, өргөх төхөөрөмжийн онцлог • Ерөнхий хөдөлмөр хамгаалал • Кран, өргөх төхөөрөмжийг төхөөрөмжлөх аюулгүй ашиглах дүрмийн ерөнхий агуулга • Кран, өргөх төхөөрөмжийг ашиглахад оролцдог субъектийн ажиллах журам • Ачаа өргөх, шилжүүлэх үед гараар өгөх дохионы төрөл, хэлбэр, хэрэглээ • Ачааг баглаж, оосорлох, өрж хураах журам • Хөдөлмөр хамгаалал, ачаа шилжүүлэх үеийн аюулгүй ажиллагаа • Ачаа оосорлох хэрэгсэл, дэгээ, тэнжээ, ган татлага, ган татлага гологдолд гаргах гэх мэт
5	Хэлбэр	Онол болон практик хосолсон байдлаар
6	Тавигдах шаардлага	<u>Сургалтын байгууллагад:</u> • Эрх бүхий байгууллагаас тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй байх; • Тухайн чиглэлээр 5-аас доошгүй жил үйл ажиллагаа явуулж байсан туршлагатай; • Сүүлийн 3 ба түүнээс дээш жил уул уурхайн салбарт тухайн чиглэлээр сургалт явуулж байсан туршлагатай; • Сургалтын хөтөлбөртэй, түүний дагуу сургалтыг явуулах; • Сургалтын өөрийн анги, танхим, техник, тоног төхөөрөмжтэй байх; • Сургалтыг хэрэглэгдэхүүн, гарын авлагаар хангах; • Тухай сургалтын агуулга, хугацаа, хамрах хүрээ зэргээс шалтгаалан мэргэжлийн багш нартай байх; • Сургалтад хамрагдсан ажилтнуудад мэргэжлийн үнэмлэх олгох.

		<u>Сургагч багшид:</u> • Сургагч багш нь тухайн чиглэлийн мэргэжлийн бөгөөд мэргэшсэн байх; • Сургагч багш нь тухайн чиглэлээр 3 ба түүнээс дээш жил ажилласан ажлын туршлагатай байх; • Илтгэх ур чадвар, багшлах ёс зүй хэм хэмжээг мөрддөг байх; • Холбогдох хууль тогтоомжийн шинэчлэлт, эрх зүйн зохицуулалтын хүрээнд явуулах.
7	Хамрах хүрээ	30 ажилтан /Салбарын ажилтнууд/
8	Хугацаа	2020 оны IV улиралд
		24 академик цаг /сургалтын агуулгаас шалтгаалан сургалтын цагийг нэмж, хасах боломжтой/
		“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн ээлжийн хуваариас шалтгаалан сургалтыг давтамжтай явуулах
9	Төсөв	Сургалтын танхим, сургагч багшийн цалин, сургалтын хэрэглэгдэхүүн болон бусад зардал
10	Байршил	Улаанбаатар хотод
11	Үр дүн	Сургалтад хамрагдсан ажилтны мэдлэг, ур чадвар нэмэгдэж, ажлын бүтээмж өснө.